

ИДЭР ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ЖУРАМ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Идэр их сургуулийн сургалтын зорилго нь төрөөс дээд боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын жишиг, хандлагад нийцсэн боловсролыгиргэнд олгоход орших ба энэ журмаар Идэр их сургуулийн сургалтын үйл ажиллагаа, түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулна.

НЭГ. СУРГАЛТЫН ТӨРӨЛ ХЭЛБЭР

- 1.1 Идэр их сургуулийн сургалтын үйл ажиллагааг ерөнхий захирал, сургалтын асуудал эрхэлсэн дэд захирал, сургалтын албад, тэнхимийн эрхлэгч нар удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.
- 1.2 Сургалтын үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө өгөх сурган, заах арга зүйн зөвлөлүүдийг ерөнхий захирлын тушаалаар байгуулан ажиллуулна.
- 1.3 Сургалтын үйл ажиллагаа намар, хаврын гэсэн хоёр үндсэн улиралд хуваагдах баөвөл, зуны сургалт,бакалавр, магистр, эчнээ, орой, зайн (онлайн) сургалтыг зохион байгуулна.
- 1.4 Намар, хаврын улирлын сургалтын үргэлжлэх хугацаа тус бүр 16 долоо хоног, улирлын шалгалтын үргэлжлэх хугацаа 2 долоо хоног байна. Хичээлийн 1 цаг нь 45 минут байх ба хоёр цагийн хичээлийг завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулна.
- 1.5 Өвөл, зуны улирлын сургалтын үргэлжлэх хугацаа 4 долоо хоног байна.Сургалтын албаас өвөл, зуны сургалтанд хамрагдаж суралцах хүсэлт гаргасан оюутны хичээл сонголт, тухайн хичээлийг хариуцан явуулах тэнхимийн саналыг харгалзан, хичээлийн хуваарь гаргана. Өвөл, зуны сургалтанд одтой (*) болон мэргэшүүлэх хичээл хамрагдахгүй.
- 1.6 Идэр их сургуулийн оюутны суралцсан хугацааны хуримтлуулсан үнэлгээний голч дүн 2.7 ба түүнээс дээш, цуглуулсан нийт кредит нь 70 кредитээс багагүй бол оюутан давхар мэргэжил эзэмшихээр суралцах эрхтэй.
- 1.7 Давхар мэргэжлээр суралцаж буй оюутан үндсэн мэргэжлээрээ төгссөний дараа, энэ дипломыгнь үндэслэн 2 дахь мэргэжлийг хариуцан ажиллаж байгаа тэнхимийн эрхлэгч кредитийн дүйцүүлэлт хийж, сургалтын албаар дамжуулан ерөнхий захиралд санал хүргүүлнэ.

ХОЁР. СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

2.1 Элсэлт

- 2.1.1 Идэр их сургуульд элсэн суралцаж буй элсэгчдийг ерөнхий захирлын тушаалаар баталгаажуулан, сургуулиас оюутны код, үнэмлэх олгоно.
- 2.1.2 Шинээр элсэн суралцаж буй оюутан бүрт зөвлөх багш томилон ажиллуулна. Зөвлөх багш нь оюутанд суралцах үйл ажиллагаагаа төлөвлөхөд нь туслах үүрэгтэй.
- 2.1.3 Гадаадын их, дээд сургууль болон дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн иргэд Идэр их сургуульд элсэн суралцах хүсэлт гаргасан тохиолдолд дээд боловсролын дипломыг үндэслэн шалгалтгүйгээр элсүүлж суралцуулна.

2.2 Шалгалт

- 2.2.1 Идэр их сургуульд хавар, намрын улирлын эцэст буюу жилдээ 2 удаа албан ёсны шалгалт авна.Тухайн улиралд 1-2 хичээлд хангалтгүй үнэлгээ авсан оюутан дараа улирлын хичээл эхэлсэнээс хойш 30 хоногийн дотор сургалтын албанаас гаргасан хуваарийн дагуу тухайн хичээлийн дахин шалгалт өгнө.
- 2.2.2 Оюутан хүндэтгэх шалтгааны улмаас улирлын шалгалтанд нөхөн орж байгаа бөгөөд түүний өмнө авсан явцын оноо 30-с дээш бол төлбөр төлөхгүйгээр шалгалтанд орох эрхтэй.
- 2.2.3 Дахин шалгалтанд орох оюутан тухайн хичээлийн кредитийн төлбөрийн 30% тай тэнцэх мөнгийг санхүүд тушаан шалгалтанд орно.
- 2.2.4 Дахин шалгалтанд хангалтгүй үнэлгээ авсан оюутан кредит нөхөх сургалтанд хамрагдаж хоёр дахь удаагаа дахин шалгалтанд орж болно. Хоёр дахь удаагийн дахин шалгалтанд унавал тухайн хичээлээр цааш суралцах, шалгалт өгөх эрхгүй болно.

2.3 Дадлага

- 2.3.1 Дадлагын багц цагийг тэнхимийн дадлагын кредит цуглуулах журмын дагуу цуглуулах бөгөөд хамгийн багаар бодоход суралцах хугацаандаа 6 багц цагийг заавал цуглуулна.
- 2.3.2 Албан ёсны дадлагад (сургалтын төлөвлөгөөнд орсон) хамрагдан 60-аас дээш оноо авсан оюутнууд уг

дадлагад харгалзах кредитийг авна.

- 2.3.3 Дадлагын ажлаар оюутан бүрийн авах оноог дадлагын тайлан хамгаалуулах комисс, дадлага удирдагч багш үнэлж тогтооно.
- 2.3.4 Багшийн туслахаар ажилласан оюутны 32 цагийн ажлыг 1 кредитээр тооцно. Ийм маягаар цуглуулсан кредит оюутны суралцах хугацаанд 3-аас ихгүй байна.

2.4 Оюутны шилжилт

2.4.1 Шилжин суралцах хүсэлт гаргаж буй оюутан доорх баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Хувийн өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Ерөнхий шалгалтын батламж
- Анх элсэн орсон сургуулийн томилолт/эх хувь/
- Оюутнаар батлагдсан тухай шилжүүлж буй сургуулийн ректорын болон захирлын тушаалын хуулбар
- Гадаадаас шилжин ирж буй оюутныг Идэр их сургуульд шилжүүлэн авахыг зөвшөөрсөн БСШУЯ-ны албан бичиг /Зөвхөн засгийн газар хоорондын гэрээгээр суралцаж буй оюутанд хамаарна/
- Суралцаж байсан сургуулийн тодорхойлолт /Захирлын гарын үсэг бүхий албан бичиг/
- Сурлагын дүнгийн баталгаажуулсан жагсаалт
- Хувийн хэрэг

2.4.2 Чөлөө авах хүсэлтэй оюутны сургалтын төлбөрийн тооцоог бодохдоо оюутан суралцсан хугацааны зардал, чөлөө авч буйтай холбогдон гарах үйлчилгээний төлбөр зэргээс хамааруулан:

Оюутны төлбөл зохих төлбөр= А+В байдлаар тооцох бөгөөд

А- нь оюутны суралцсан хугацааны зардал, В- нь чөлөө авч байгаатай холбогдон гарах үйлчилгээний зардалболно. Оюутны суралцсан хугацааны /А/ зардлыг тооцохдоо оюутны нэгж зардлыг суралцсан долоо хоногийн тоогоор үржүүлэн гаргана. Оюутны нэгж зардал нь улирлын сургалтын төлбөрийг 16 долоо хоногт хуваасантай тэнцүү байна. Оюутны чөлөө авч буйтай холбогдон гарах үйлчилгээний төлбөр /В/-ийг тухайн хичээлийн жилийн хэвийн ачаалалтай суралцаж байгаа оюутны 0.5 кредитийн үнэлгээтэй дүйцүүлж тооцно.

2.4.3 Тухайн мэргэжлийг хариуцан ажиллаж байгаа тэнхим нь хоёр дахь мэргэжил эзэмших болон эчнээ сургалтаар Идэр их сургуульд элсэн орсон хүмүүсийн дээд боловсролын дипломыг үндэслэн дүйцүүлэн тооцох хичээл байгаа эсэхийг тэнхимийн эрхлэгч нягтлан үзэж, саналаа сургалтын албанд хүргүүлнэ.

2.4.4 Оюутны тухайн хичээлийн кредит ба үнэлгээ дүйцүүлэгдэхээр шийдвэр гарсан тохиолдолд, оюутан нь дүйцүүлэгдсэн кредит бүрд нэг кредитийн үнэлгээний 10 хувьтай тэнцэх хураамжийг Идэр их сургуулийн дансанд шилжүүлнэ.

2.5 Төгсөлтийн ажил

2.5.1 Дипломын төсөл, ажлын хамгаалалт, төгсөлтийн шалгалтыг Идэр их сургуулийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан төгсөлтийн комисс удирдан явуулна. Уг комисс нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй ажиллана. Дипломын төслийн сэдвийг намрын улиралд 13-р долоо хоногт багтаан дэд захирлаар батлуулсан байна.

2.5.2 Удирдагч багшийн үнэлгээ. Багшийн үнэлгээний дээд оноо 50 байх бөгөөд ямар шалгуураар төгсөх оюутны дипломын төсөл, ажлыг үнэлэхээ багш бүр тодорхойлж, тэнхимдээ зөвшилцсон байна. Удирдагч багш урьдчилсан хамгаалалтаас нэг долоо хоногийн өмнө төгсөх оюутны үнэлгээг, тодорхойлолтын хамт дипломын төсөл, ажил хамгаалалтын комиссын нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

2.5.3 Урьдчилсан хамгаалалт. Урьдчилсан хамгаалалтыг холбогдох тэнхим, комиссын дарга, нарийн бичгийн дарга нар хариуцан зохион байгуулж, дипломын төсөл, ажлын хамгаалалтаас нэг долоо хоногийн өмнө зарлан хуралдуулна.

2.5.4 Урьдчилсан хамгаалалтаар төгсөх оюутанд олгох оноо нь $\square 20$ хүртэл байх бөгөөд ажлын гүйцэтгэл, хамгаалсан байдлаас шалтгаалан удирдагч багшийн үнэлгээг бууруулж болно.

2.5.5 Төгсөлтийн ажил хамгаалуулах комисс төгсөж буй оюутны илтгэл, асуултанд хариулсан байдал, шүүмж удирдагч багшийн тодорхойлолтзэргийг үндэслэн, дипломын төсөл, ажлын хамгаалалтын дүнг $\square 30$ хүртэл оноогоор дүгнэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл урьдчилсан хамгаалалтын дүнг бууруулж болно. Комисс төгсөх оюутан бүрээр дипломын төсөл, ажлын эцсийн дүнг гаргаж, тэмдэглэл хөтөлнө.

2.5.6 Төгсөлтийн шалгалт, тест нь сургуулийн ерөнхий захирлын гарын үсэг, тамгаар баталгаажсан байна.

2.5.7 Төгсөх оюутан дипломын төсөл, ажил болон төгсөлтийн шалгалтыг “С” ба түүнээс дээш дүнтэй хамгаалах, өгөх үүрэгтэй. Дипломын төсөл, ажлаа амжилтгүй хамгаалсан болон төгсөлтийн шалгалтанд амжилтгүй дүн үзүүлсэн оюутнуудыг тодорхой хугацаагаар хойшлуулах ба уг хугацааг төгсөлтийн комиссоос тогтоон, энэ тухай тогтоолд тусгана.

2.6 Диплом олголт

2.6.1 Идэр их сургуулийн бакалаврын түвшний сургалтыг 3.6 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй төгсөж байгаа төгсөгчдөд тухайн мэргэжлийн бакалаврын зэргийн “Онцлох” тусгай тэмдэг дарсан диплом олгоно. Төгсөгчдөд тухайн мэргэжлийн хөтөлбөр олон улсын мэргэжлийн байгууллагуудаар магадлан итгэмжлэгдсэн тухай тэмдэглэл бүхий диплом олгож болно.

2.6.2 Дээд боловсролын диплом, дипломын хавсралтыг шинэчлэн солиулах, нөхөн авах хүсэлт гаргаж холбогдох материал бүрдүүлсэн төгсөгчийнтөлвөл зохих хураамжийн хэмжээ нь Идэр их сургуулийн тухайн жилийн 3 кредитийн үнэлгээтэй тэнцүү байна.

ГУРАВ. ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

3.1 Оюутны мэдлэгийг хоёр үе шаттайгаар үнэлнэ.

1. Уг хичээлээр оюутан эзэмшвэл зохих мэдлэгийг олж авахын тулд улирлын турш хэрхэн сурч хөдөлмөрлөснөө тухайн хичээл заасан багшаар 70 хүртэл оноогоор үнэлүүлнэ.

2. Хичээлийн төгсгөлд эзэмшсэн мэдлэгийн түвшинг улирлын шалгалтын 30 хүртэл оноогоор үнэлүүлнэ. Эдгээрийн нийлбэр 100 хүртэл оноог доорх хүснэгтийг ашиглан үсгэн үнэлгээнд шилжүүлнэ. Дүнгийн үнэлгээ нь үсгээр, үгээр, тоогоор, хувиар байж болох бөгөөд тэдгээрийн харьцааг олохдоо лавлах хүснэгтийг хэрэглэнэ.

ОНОО	ҮСГЭН ҮНЭЛГЭЭ	ГОЛЧ ОНОО
100	A	4
99	A	3.95
98	A	3.9
97	A	3.85
96	A	3.8
95	A	3.75
94	A	3.7
93	A	3.65
92	A	3.6
91	A	3.55
90	A	3.5
89	B	3.45
88	B	3.4
87	B	3.35
86	B	3.3
85	B	3.25
84	B	3.2
83	B	3.15
82	B	3.1
81	B	3.05
80	B	3
79	C	2.9
78	C	2.8

77	C	2.7
76	C	2.6
75	C	2.5
74	C	2.4
73	C	2.3
72	C	2.2
71	C	2.1
70	C	2
69	D	1.9
68	D	1.8
67	D	1.7
66	D	1.6
65	D	1.5
64	D	1.4
63	D	1.3
62	D	1.2
61	D	1.1
60	D	1
59.9	F	0

3.2 Оюутан хичээлийн явцаас 29 ба түүнээс доош оноо авсан тохиолдолд багш тухайн оюутанд W тэмдэглэгээ тавина.

3.3 Багш хичээлийн явцад оюутны идэвх, оролцоог дараах байдлаар үнэлнэ.

1. Ирц - Тухайн хичээл дээр оюутан 20 хүртэл оноо авах бөгөөд нийт цагийн хэдэн хувьд нь сууна, ирцийн онооны төчнөөн хувийг авна. Оноог бодохдоо: - тасалсан 1 цаг,- чөлөөтэй 2 цаг, - өвчтэй 3цаг тус бүрийг суугаагүй нэг цаг гэж үзнэ. 1 цаг гэж академик цагаар 45 минутыгтооцно.
- 2.Завсрын шалгалт - Хичээл зааж буй багш улирлын явцад 2 удаа завсрын шалгалт авна. Оюутнууд нэг удаагийн завсрын шалгалтаар 10 хүртэл оноо авна.
3. Идэвхи, бие даалт - Оюутан идэвхи болон бие даалтын ажлын нийлбэрээр 30 хүртэл оноо авах бөгөөд энэ нь тухайн оюутан хичээлийн явцад хэр идэвхитэй, санаачлагатай оролцдог гэдгийг харуулах үзүүлэлт юм. Багш ангийн оюутнуудын идэвхийн ба бие даалтын оноог тус бүрд нь гаргаж улирлын шалгалт болохоос өмнө 7-оос цөөнгүй хоногийн өмнө бичгээр мэдээлнэ.

ДӨРӨВ. БАГЦ ЦАГ

4.1 Оюутны сурах үйл ажиллагаанд зарцуулах дараах үйл ажиллагааг нэг кредит цаг гэж тодорхойлно. Үүнд:

- 16 цагийн лекц
- 32 цагийн семинар
- 24 цагийн лаборатори
- 24 цагийн дадлага

4.2 Багц цагийг дараах тохиолдолд анализ хийх. шийдвэр гаргахад чухал баримт болгон ашиглана. Үүнд:

- a) Эхний хичээлийн жилийн дараа оюутны сурах чадварыг тодорхойлж дүгнэлт гаргахад
- b) Дадлагын ажилд гарах зөвшөөрөл өгөхөд
- c) Бакалаврын болон дипломын зэрэг олгоход

d) Өөр сургуулиас оюутан шилжиж ирэхэд

e) Сургалтын явцыг судлахад

4.3 Оюутан сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд дараагийн улиралд суралцахаар төлөвлөсөн хичээлүүдээ UNIMIS системийн оюутны вэб хуудсаар сонгож, сургалтын албанд бүртгэл хийлгэнэ.

4.4 Оюутан хичээл сонголт хийхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

4.4.1 Оюутан өөрийн суралцаж байгаа мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг сайтар судална.

4.4.2 Оюутан өөрийн зөвлөх багштай уулзаж тодорхой зөвлөгөө авна.

4.4.3 Оюутанд улирал бүрийн хичээл сонголтыг оновчтой зөв хийхэд нь зөвлөх багш зөвлөж, хянаана.

4.4.4 Оюутан суралцах хичээлүүдээ өөрийн мэдлэг, чадвар, санхүүгийн боломжийг тооцоолсны үндсэн дээр хариуцлагатай сонгоно.

4.5 Оюутны 1 улирлын ачаалал 21 кредитээс хэтрэхгүй байна. Дадлагын хичээл энэ ачаалалд орохгүй. (Улирлын кредит сонголтын доод хэмжээ 12 кредит байна.)

4.6 Тухайн хичээлийг 12 ба түүнээс дээш оюутан сонголт хийсэн тохиолдолд анги бүрдсэн гэж тооцож сонголт баталгаажна.

4.7 Хоорондоо уялдаа холбоо бүхий хичээлийн өмнөх шалгалтыг өгөөгүй оюутан дараагийн хичээлийг судлах боломжгүй.

4.8 Оюутан улирлын эцэст өөрийн сурлагын амжилтандаа дүн шинжилгээ хийж, сургуулийн нэгдсэн стандартад заасан Үнэлгээний голч дүнгийн түвшний шаардлагыг хангаж байгаа эсэхээ хянаж, цаашид суралцах арга барилаа төлөвлөнө.

4.9 Бакалаврын 3-р дамжааг 3.2-оос дээш голчтой дүүргэсэн, мэргэжлийн чиглэлээрээ магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй оюутан холбогдох тэнхим, сургалтын албаны зөвшөөрлөөр магистрын судалгааны арга зүй, мэргэжлийн хичээлүүдээс сонгон судлах боломжтой. Бакалаврын зэрэг авсны дараа тухайн магистрын хөтөлбөрт элсэн орж судалсан хичээлээ тооцуулна.

4.10 Үнэлгээний голч дүн (GPA). Үнэлгээний голч дүнг тооцохдоо, хичээл бүрийн үнэлгээний хувийг тухайн хичээлийн харгалзах кредитээр үржүүлж, дундажлах замаар тодорхойлно.

Улирлын болон хуримтлуулсан үнэлгээний голч дүнг дараах ерөнхий томъёогоор тооцоолно.

Үнэлгээний Голч Дүн (GPA) = $\frac{\text{Чанарын онооны нийлбэр}}{\text{Кредит цагийн нийлбэр}} = \frac{Y1 * K1 + Y2 * K2 + \dots + Yn * Kn}{K1 + K2 + \dots + Kn}$

Кредит цагийн нийлбэр $K1 + K2 + \dots + Kn$

Энд, Y1, Y2, ..., Yn нь харгалзан 1,2,...,n дүгээр хичээлүүдийн үнэлгээний хувь,

K1, K2, ..., Kn нь харгалзан 1,2,...,n дүгээр хичээлүүдийн кредит болно.

ТАВ. ЧАНАРЫН ШААРДЛАГА

5.1 Идэр их сургуулийн бакалаврын зэргийн дипломыг 2.0 ба түүнээс дээш, магистрын зэргийн дипломыг 3.0 ба түүнээс дээш, докторын зэргийн дипломыг 3.2 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан төгсөгчдөд олгоно.

5.2 Улирлын үнэлгээний голч дүн нь 0.7-оос доош бол оюутныг “Тухайн улиралд хангалтгүй суралцсан” гэж үзнэ. Хангалтгүй суралцсан оюутны нэрийг “Анхааруулгын хуудас”-нд бичиж сануулна. Оюутны нэр анхааруулгын хуудсанд 3 улирал дараалан бичигдсэн тохиолдолд сурлагаар тэнцээгүй гэж үзэж сургуулиас хасна.

5.3 Оюутан дараалсан хоёр улиралд тав ба түүнээс дээш хичээлийн шалгалтанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ороогүй буюу хангалтгүй дүн үзүүлсэн бол сургуулиас хасах санал оруулна.

5.4 Оюутны үзэж судалсан хичээл 60 кредит хүрсэн боловч үнэлгээний голч дүн нь 1.5–аас доош бол шинээр хичээл нэмж үзэхийг зогсоож, өмнө нь хангалтгүй үнэлгээ авсан хичээлүүдийг судлуулна.

5.5 Оюутан 3 ба түүнээс дээш улирал өнгөрсний дараа тодорхой хичээлийн үнэлгээг дээшлүүлэхийг хүсвэл уг хичээлийг заавал дахин сонгож судлана. Оюутны дахин сонгож суралцахаар бүртгүүлсэн хичээлийг, шинээр үзэхээр сонгосон хичээлүүдийн нэгэн адил бүртгэж төлбөрийг төлүүлнэ.

5.6 Оюутан дипломын ажил бичихийн тулд өмнө нь 90 кредит цуглуулсан байх шаардлагатай ба суралцсан хугацааны үнэлгээний голч дүн 3.0 байна. 3.0-аас бага бол төгсөлтийн шалгалт өгнө.

ЗУРГАА. ЖУРМЫН НЭР ТОМЪЁО

6.1 Дээд боловсролын зэрэг. Багц цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын гэсэн шатлалтай байна.

6.2 Дипломын ба бакалаврын зэрэг. Дээд боловсролын анхан шатны зэрэг бөгөөд эдгээр шатлалд суралцагчийг оюутан гэнэ.

- 6.3 *Магистрын зэрэг.* Дээд боловсролын бакалаврын дараах шатны зэрэг бөгөөд энэ шатлалд суралцагчийг магистрант гэнэ.
- 6.4 *Докторын зэрэг.* Дээд боловсролын магистрын дараах шатны зэрэг бөгөөд энэ шатлалд суралцагчийг докторант гэнэ.
- 6.5 *Суралцагч.* Оюутан, магистрант, докторантыг нийтэд нь суралцагч гэнэ.
- 6.6 *Хичээлийн цаг.* Академик 2 цагаар нийт 90 минут хичээллэнэ.
- 6.7 *Хөтөлбөр.* Хоорондоо уялдаа холбоотой бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн (хөтөлбөрийн танилцуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших ур чадвар, суралцагчийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа) тодорхой шатны боловсролын зэрэг олгоход нийцүүлсэн суралцагчийн суралцах хөтөлбөр
- 6.8 *Үндсэн мэргэжил.* Оюутны суралцах үндсэн чиглэл буюу тухайн шинжлэх ухааны тодорхой мэдлэг, чадвар, дадлыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр бакалаврын зэрэг олгох түвшинд эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.
- 6.9 *Хавсарга мэргэжил.* Тодорхой болзол хангасан оюутанд суралцаж байгаа үндсэн мэргэжлийн зэрэгцээ өөр мэргэжлийн чиглэлээр системтэй мэдлэг эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.
- 6.10 *Хос мэргэжил.* Тодорхой болзол хангасан оюутанд суралцаж байгаа үндсэн мэргэжил болон чиглэлээр хоёр дахь мэргэжлийг эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.
- 6.11 *Гүнзгийрэн мэргэжих.* Үндсэн мэргэжлийн дагуу гүнзгийрэн судлахад чиглэгдсэн багц хичээл.
- 6.12 *Сургалтын төлөвлөгөө.* Хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд судлах хичээлийн жагсаалт, агуулгын багтаамж, дараалал төрлийг тусгасан баримт бичиг.
- 6.13 *Хичээлийн хөтөлбөр.* Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийн индекс, суралцагчийн эзэмшвэл зохих онолын болон практик мэдлэг, чадварын агуулга, сэдэвчилсэн төлөвлөгөө, үнэлгээ, арга зүй, тухайн хичээлийн багтаамж /багц цаг/, ашиглавал зохих ном, сурах бичиг, эх сурвалжийн жагсаалтыг тодорхойлсон баримт бичиг.
- 6.14 *Ерөнхий суурь хичээл.* 1. Нийгэм, хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухааны суурь мэдлэг, ур чадвар. 2. Эзэмшсэн мэдлэг, ур чадвараа амьдралд бүтээлчээр бодитой ашиглах дадал олгох үндсэн зорилго бүхий дээд боловсролын суурь судлагдахуун.
- 6.15 *Мэргэжлийн суурь хичээл.* Суралцагчийн суралцах үндсэн чиглэлийнх нь шинжлэх ухааны суурь мэдлэгийг олгох, тухайн салбарт асуудал шийдвэрлэх, бүтээлчээр сэтгэх, мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээл.
- 6.16 *Мэргэжлийн хичээл.* Тодорхой мэргэжлийн мэдлэг, ур чадвар өгөхөд чиглэгдсэн оюутанд шинжлэх ухаан, мэргэжлийн чиглэл, салбараар төвлөрч, гүнзгийрэн судлах боломж олгодог заавал болон сонгон судлах хичээл.
- 6.17 *Заавал судлах хичээл.* Тухайн хөтөлбөрийн хувьд зайлшгүй судлах шаардлагатай хичээл.
- 6.18 *Сонгон судлах хичээл.* Тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүлэг бүрээр авбал зохих багц цагийг судлах зорилгоор тодорхой бүлэг хичээлүүдээс суралцагч өөрөө сонгон судлах хичээл.
- 6.19 *Залгамж хичээл.* Тодорхой хичээлийг судлахаас өмнө амжилттай судалсан байвал зохих хичээл.
- 6.20 *Зэрэгцүүлэн судлах хичээл.* Тухайн хичээлтэй зэрэгцүүлэн судалж болох хичээл.
- 6.21 *Чөлөөт сонголтын хичээл.* Суралцагч өөрийн хүсэл сонирхлоор сонгох боломжтой Идэр их сургуулиас санал болгож байгаа бүх хичээл. Тухайн сонгож буй хичээл нь залгамж холбоотой бол өмнөх хичээлийг заавал үзсэн байна.
- 6.22 *Лекцийн хичээл.* Шинжлэх ухааны онолын суурь мэдлэгийг системтэй өгөх зорилготой багшийн тайлбарлан ярих болон сурган хүмүүжүүлэх бусад арга, хэрэгсэлийг хэрэглэж буй сургалтын хэлбэр юм.
- 6.23 *Семинарын хичээл.* Онолын материалыг гүнзгийрүүлэн судлах, ерөнхийлөн дүгнэх, сэтгэхүйн шүүмжлэлт шинжийг хөгжүүлэх, мэдлэг хуримтлуулах, бүтээлч санаачлага болон ур чадварт суралцах, эргэцүүлэл хийх, өөрийн үзэл бодлыг үндэслэлтэй хамгаалах, илэрхийлэх дадал бүрэлдүүлэхэд чиглэгдсэн сургалтын хэлбэр юм.
- 6.24 *Лабораторийн хичээл.* Анги, лабораторид багшийн тусламжтайгаар суралцагч онолын мэдлэгийг бодит

амьдралын үйл ажиллагаанд чиглэсэн туршилт дээр үндэслэн дадлага олгох буюу ажлын ур чадвар эзэмшүүлэх хичээл. Тус хичээл нь лаборатори доторхи багаж төхөөрөмж хэрэглэх, лабораторийн тайлан бичих, өгөгдөлд дүн шинжилгээ хийх гэх мэт бие даалтын хэлбэрийг агуулж болно.

6.25 *Дадлага.* Хамтарсан сургалт, сургууль байгууллага хоорондын гэрээний дагуу олгож буй дадлага, дагалдан судлах зэргээр мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилготой.

6.26 *Багц цаг.* Кредит нь боловсролын агуулгын багтаамжийг жиших нэгж бөгөөд оюутны суралцах ачаалал, багшийн сургалтын ажлын хэмжээ, сургалтын төлбөрийг тогтоох үндсэн хэмжүүр, дээд боловсролын зэрэг олгох сургалтад тавих стандартын шаардлага, сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, зохион байгуулалтын харилцааг зохицуулах үндэслэл болно .